

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 01 сарын 12-ны өдөр

Дугаар ...

БА-024/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 1 давхар 24.0м*8.0м хэмжээтэй операторын барилга, 30м3 хүчин чадалтай 3 ширхэг, 50м3 хүчин чадалтай 2 ширхэг нийт 5 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 11 сарын 20-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023-08-18 огноо, БАЗГ2023/545 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: 2104-ОТТТС-1085;

2.3. Захиалагч: Ойн Бирж ХХК оноосон нэр, 9011068066 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2026945 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, нарны зам, Тэс төвийн байр, 201 тоот, 70113003 холбоо барих утас, Info@oinbirj.mn цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Тэс Петролиум ХХК оноосон нэр, 9011068065 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2658445 регистрийн дугаар, БУ16-219/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, нарны зам, Тэс төвийн байр, 201 тоот, 70113003 холбоо барих утас, Info@tespetroleum.mn цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Эм Пи Ай Консалтантс ХХК оноосон нэр, 9011099068 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2662671 регистрийн дугаар, ЗТ11-368/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн бүс, 52-р байр, 976-11-310816 холбоо барих утас,

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Ойн Бирж ХХК оноосон нэр, 9011068066 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2026945

УСНЫ БҮРТГЭЛИЙН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, нарны зам, Тэс төвийн байр, 201 тоот, 70113003 холбоо барих утас, Info@oinbirj.mn цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 1 давхар 24.0м*8.0м хэмжээтэй операторын барилга, 30м³ хүчин чадалтай 3 ширхэг, 50м³ хүчин чадалтай 2 ширхэг нийт 5 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:


Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;



в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 24.0м*8.0м хэмжээтэй операторын барилга, 30м³ хүчин чадалтай 3 ширхэг, 50м³ хүчин чадалтай 2 ширхэг нийт 5 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Ойн бирж ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 1 давхар 24.0м*8.0м хэмжээтэй операторын барилга, 30м³ хүчин чадалтай 3 ширхэг, 50м³ хүчин чадалтай 2 ширхэг нийт 5 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:
Ойн бирж ХХК-ийн захирал



(А.Мөнгөн)

(Т.Батчулуун)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО, ОЙН БИРЖ ХХК-ИЙН
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 24.0М*8.0М ХЭМЖЭЭТЭЙ ОПЕРАТОРЫН
БАРИЛГА, 30МЗ ХҮЧИН ЧАДАЛТАЙ 3 ШИРХЭГ, 50МЗ ХҮЧИН ЧАДАЛТАЙ 2
ШИРХЭГ НИЙТ 5 ШИРХЭГ ДАЛД САВ БҮХИЙ ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН
БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 11 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Ойн Бирж ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 1 давхар 24.0м*8.0м хэмжээтэй операторын барилга, 30мЗ хүчин чадалтай 3 ширхэг, 50мЗ хүчин чадалтай 2 ширхэг нийт 5 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын нэг давхарт 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр 13:00 цагт 13 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 14 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн дарга
О.Оджаргал
2. Комиссын нарийн бичгийн дарга:
Захиалагч Ойн Бирж ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Т.Батчулуун
3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй
байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн
хяналтын улсын /ахлах/ байцаагч
Б.Шинэжаргал
4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн
стандартын хяналтын хэлтэс,
Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч
Б.Найрамдал
5. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн
стандартын хяналтын хэлтэс,
Газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагч
Б.Мөнхболд
6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК,
Техник хяналтын инженер
Б.Цэрэннадмид
7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК
Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар
Сүлжээ төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Ц.Дагвадорж
8. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх
төвийн менежер
Г.Үүрийнгэгээ
9. Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймрийн
улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл
хяналтын тасаг, дэд хурандаа
Ч.Артаг
10. Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын
архивын архивч
Н.Өлзийжаргал
11. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс,
Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд
хүлээн авах, Норм нормативын сангийн
бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн
О. Ундрал
12. Зураг төсөл зохиогч байгууллага
Эм Пи Ай Консалтантс ХХК-ийн
зургийн инженер
Б.Содбилэг

13. Барилгын ажил гүйцэтгэгч

Тэс Петролиум ХХК-ийн ерөнхий инженер

Н.Лхагвасүрэн

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 13
- Хүрэлцэн ирсэн - 13
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 13

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Ойн Бирж ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 1 давхар 24.0м*8.0м хэмжээтэй операторын барилга, 30м³ хүчин чадалтай 3 ширхэг, 50м³ хүчин чадалтай 2 ширхэг нийт 5 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналтын шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНБД11-04-16 дагуу зохиогч дүгнэлт өгөх
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх
- Бетон хашааны суурийг хүчитгэх, хөрс нуралтаас хамгаалах арга хэмжээ авах

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн дарга, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **Б.Найрамдал:**

- Техникийн нөхцөл сунгасан бол шалгуулах, хүчин чадал нэмэгдүүлэх
- Машин засварын барилгад хүрээ газардуулга хийж, тоноглолыг холбож хэмжилт туршилт хийж баталгаажуулах
- Зурагт тусгасан сэлгэн залгагч суурилуулах, II зэрэглэлд хамаарагдах объект тул бэлтгэл тэжээл шийдвэрлэх
- Үерийн улмаас барилга байгууламж, шугам тоноглолыг хамгаалах арга хэмжээг авч ажиллах
- Газардуулгын хүрээг далдлах, системийг дахин шалгах
- НХШГ-ийн хүргүүлсэн 2 мэдэгдлийн хариуг ирүүлэх
- КТПН ашиглалтад оруулсаныг шалгуулах

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагч **Г.Мөнхболд:**

- Шатахуун хадгалах савнуудад техникийн магадлал хийлгэх, улсын бүртгэлд хамруулж паспортжуулах
- Шингэрүүлсэн шатдаг хий хадгалах савыг татан буулгах
- ШТС-ын үнийн самбыг шинэчлэх, ШШХ-г хасах

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын байцаагч **Б.Шинэжаргал:**

- Барилгад ашигласан материалын тохирлын гэрчилгээ,улаан журнал, ил далд ажлын акт, бетоны бат бэхийн шинжилгээний бичиг шалгуулах
- Зураг, төсөл зохиогч өөрчлөлтийн зураг төслийг баталгаажуулж тайлбар тодруулга ирүүлэх



Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, техник хяналтын инженер **Б.Цэрэннадмид:**

- Дэд өртөөнд чадлыг засах, Д...дугаар тавих
- ЕОС, ХС-уудад хая бичиглэл схем байршуулах

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, ерөнхий инженер **Ц.Дагвадорж:**

- Авто засварын хэсэгт хяналтын камер суурилуулах

Ус сувгийн удирдах газар, хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Г.Үүрийнгэгээ:**

- Нөөцийн /цэвэр усны/ савны хэмжээг зурагт 2м3 байхаар тусгагдсан боловч 1м3 хүрэхгүй хэмжээтэй угсрагдсан, ус өгөх хоолой хийгдээгүй учраас хийж гүйцэтгэх
- Усны нөөцийн савнаас сорьц авч дүгнэлтийг шалгуулах, унд ахуйн усны MNS0900:2018 стандарт хангаж буй эсэх
- Зөөврийн усны гэрээг хийх, шалгуулах
- Цооног угсралтын үеийн ил далд ажлыг шалгуулах, хөрсөнд нэвчихгүй гэх тайлбар, баталгаа ирүүлэх

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар, Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасаг, **Ү.Артаг:**

- Галын усан санг өвлийн улиралд хөлдөхөөс хамгаалах арга хэмжээ авах
- Бэлэн байдлыг хангаж ажиллах
- Өөрчлөлтийн зураг гаргаж хянуулах, авто засварыг оруулах

Үндэсний төв архив, зураг төслийн баримтын архивын архивч **Н.Өлзийжаргал:**

- Архивд баримт хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримтыг бүрэн бүрдэлтэй бүрдүүлэх, цоолж нуруулдаж, хуудас дугаарлаж, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичгийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх

Барилгын хөгжлийн төв, норм, нормативын хэлтэс, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, норм, нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн, **О.Ундрах:**

- Барилгын хучилт зураг төсөлд төмөр бетон цутгамал хучилт төлөвлөсөн боловч угсармал хучилтаар гүйцэтгэсэн байна. Үүн дээр зохиогч байгууллага тайлбар албан бичиг ирүүлж, зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгах
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг төлж баримт хавсаргах

Эм Пи Ай Консалтант ХХК-ийн зургийн инженер **Б.Содбилэг:**

- Аюулгүй байдлын үүднээс галын усны нөөцөд анхаарах, байнгын дүүргэлттэй байлгах үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Тэс Петролиум ХХК-ийн ерөнхий инженер **Н.Лхагвасүрэн:**

- Ойн Бирж ХХК-ийн захиалгаар зураг төслийн Эм Пи Ай Консалтантс ХХК-иар боловсруулагдсан уг ШТС-ын барилга байгууламжийн ажил зураг төслөөс өөрчлөгдсөн зүйлгүй чанартай сайн баригдсан гэж үзэж байна. Иймд уг барилга байгууламж байнгын ашиглалтанд хүлээж авна уу.

АЛГАЛТЫН
ЗАР

амжийг ашиг
лах комисс

